



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 219

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй, засвар хийхэд эдийн засгийн хувьд үр ашиггүй 17 нэрийн нийт 12,752,479.20 (арван хоёр сая долоон зуун тавин хоёр мянга дөрвөн зуун далан есөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга Ж.Бат-Өлзий нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Акталж данснаас хассан хүлэмжийн газрыг нөхөн сэргээж зориулалтын дагуу ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



132001516

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон	Тоо хэмжээ	Хэмж их нэгж	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл /төгрөг/
1	Компьютер	2008.09.19	1	ш	620,000.00	620,000.00
2	Компьютер	2010.05.01	1	ш	855,566.00	855,566.00
3	Компьютер /зөөвөр /	2013.11.30	1	ш	1,099,000.00	1,099,000.00
4	Компьютер /зөөвөр /	2016.10.06	1	ш	1,427,800.00	1,427,800.00
5	Принтер	2002.05.01	1	ш	288,446.00	288,446.00
6	Скайнер	2010.11.25	1	ш	141,557.00	141,557.00
7	Факсын аппарат	2011.11.03	1	ш	300,000.00	300,000.00
8	Таяган метр	2013.03.18	3	ш	110,000.00	330,000.00
9	Малын жин	2013.03.18	1	ш	937,243.20	937,243.20
10	Ширээ	2008.12.16	1	ш	205,000.00	205,000.00
11	Бичгийн ширээ	2009.12.30	1	ш	100,000.00	100,000.00
12	Сандап	2011.01.03	3	ш	47,339.00	142,017.00
13	Хүлэмж	2009.12.30	1	ш	3,700,000.00	3,700,000.00
14	Хүлэмж	2009.12.30	1	ш	1,037,850.00	1,037,850.00
15	Хүлэмж	2014.12.30	1	ш	610,500.00	610,500.00
16	Санхүүгийн программ	2009.05.01	1	ш	907,500.00	907,500.00
17	Цалингийн программ	2009.05.01	1	ш	50,000.00	50,000.00
	Нийт дүн					12,752,479.20 /арван хоёр сая долоон зуун тавин хоёр мянга дөрвөн зуун далан есөн төгрөг хорин мөнгө/